

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.06.04 № 03/4632

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Гомдол хянасан тухай**

Танай байгууллагаас зарласан ТБ/20240101001 дугаартай “Өвөрхангай аймаг - Хархорин тооцооны төвийн барилга угсралтын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Мотоблок” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох материалд үндэслэн хянан үзлээ.

“Мотоблок” ХХК-ийн гомдолд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Онч тэнхлэг” ХХК-ийн тендер нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1 болон ТШЗ 17.4-т заасан ижил, төстэй ажлын шаардлагыг хангаагүй, санал болгосон ачааны автомашины даац шаардлага хангаагүй, түншлэгч “Төв төгөл” ХХК ТШЗ 17.3-т заасан чадавхын шаардлагыг хангаагүй байх тул захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг хүссэн байна.

“Мотоблок” ХХК-ийн гомдолд дурдсаны дагуу захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Онч тэнхлэг” ХХК болон “Төв төгөл” ХХК-ийн түншлэлийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 17.4-т “Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-өөс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна. гэж тус тус заасан байна.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “... 2022, 2023 онуудын гэрээний үнийн дүнгийн нийлбэр нь батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй барилга угсралтын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажиллаж хүлээлгэн өгсөн байна. Гэрээний хуулбар ирүүлнэ. Гэрээний үүргээ биелүүлсэн тухай захиалагчийн тодорхойлолт эсхүл гэрээ дүгнэсэн акт /ажил хүлээлцсэн акт/-ыг ирүүлнэ.” гэж заасан байна.

“Онч тэнхлэг” ХХК болон “Төв төгөл” ХХК-ийн түншлэлийн тендерт ижил төстэй ажлын жагсаалтад дурдсан “Онч тэнхлэг” ХХК, “Пример инвест групп” ХХК-ийн хооронд байгуулсан 2022 оны “12 давхар 1 блок бүхий орон сууцны барилга угсралтын ажил” гүйцэтгэх 865.9 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ, барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт, захиалагчийн тодорхойлолт, “Төв төгөл” ХХК, Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар хооронд

байгуулсан 2023 оны "Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын барилга угсралтын ажил" гүйцэтгэх 1,566.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ, барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт, захиалагчийн тодорхойлолт зэрэг материалын хуулбарыг хавсарган ирүүлсэн нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн дээр дурдсан шаардлагыг хангасан гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д "... Тендерт санал болгож байгаа боловсон хүчний мэдээллийг ... Инженерүүдийн дипломыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шалгана..." гэж заасан байна.

"Онч тэнхлэг" ХХК болон "Төв төгөл" ХХК-ийн цахим түншлэлийн гэрээнд "... ажлын туршлага, борлуулалтын орлогыг тус тус харгалзан үзсэн болно." гэж заасан байх бөгөөд уг тендерт санал болгож буй инженер, техникийн ажилтнуудыг цахим системээр санал болгосон байх тул түншлэгч "Төв төгөл" ХХК-аас хүний нөөцийн мэдээллийг ирүүлээгүй тухай "Мотоблок" ХХК-ийн гомдол үндэслэлгүй байна.

3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д "... Техник хэрэгслийн 60 хувийг түрээсээр ашиглаж болно. - Техник хэрэгслийн мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан хянан үзэх тул улсын дугаарын мэдээллийг ирүүлнэ. - Хэрэв түрээсээр ашиглах бол түрээсийн гэрээний хуулбарыг ирүүлнэ." гэж заасан байна.

3.1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д дурдсан шаардлагатай техник хэрэгслийн жагсаалтад өөрөө буулгагч автомашин гэж заагаагүй байх тул "Онч тэнхлэг" ХХК болон "Төв төгөл" ХХК-ийн түншлэлийн тендерт гэрээт ажлыг гүйцэтгэхэд санал болгосон 5311 УБМ улсын дугаартай Sinotruck Steyr маркийн өөрөө буулгагч автомашины даацын хэмжээ зөрүүтэй тухай "Мотоблок" ХХК-ийн гомдол үндэслэлгүй байна.

3.2 "Онч тэнхлэг" ХХК болон "Төв төгөл" ХХК-ийн түншлэлийн тендерт цахим системээр санал болгосон бульдозерын түрээсээр ашиглах гэрээг хавсарган ирүүлээгүй байхад тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн дээр дурдсан шаардлагыг хангасан гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 17/2720 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "Мотоблок" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ